

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2026 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/03.

Арвайхээр сум


「Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагын тусгай зөвшөөрөл сунгах, шинээр олгох, нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2,19.3,19.14, 19.15, 19.18, дэх заалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 5.5 дугаар зүйлийн 14,15, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн “Тушаал хүчингүй болгох тухай” а/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эрүүл мэнд, эм хангамжийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох комиссын 2025 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн шийдвэрийг үндэслэн тусгай зөвшөөрлийг сунгах нэр бүхий 1 аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг нэгдүгээр хавсралтаар, нэмэлт өөрчлөлт оруулж буй нэр бүхий 2 аж ахуйн нэгж, байгууллагын нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ үнэлгээ мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргалд)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.ОЮУНТУЯА

622001012

D:My.Doc.Tushaal. EMG


Эрүүл мэндийн газрын даргын  
2026 оны 01 дугаар сарын 27-ны  
өдрийн 403 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ НЭР БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖ,  
БАЙГУУЛЛАГЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл сунгах хугацаа	Хүчинтэй байх огноо
1	“Баян дүүрэн итгэлт” ХХК “Баяндүүрэн- Итгэл” эмийн сан РД-3559378 1011005121 ЭСХ-а/84/18/13/05	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Баянгол сум	5 жил	2031.02.13- ний өдрийг хүртэл

---oOo---

Эрүүл мэндийн газрын даргын  
2026 оны 01 дугаар сарын 27-ны  
өдрийн 403 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт



ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ НЭР БҮХИЙ АЖ АХУЙН НЭГЖ,  
БАЙГУУЛЛАГЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр, регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Нэмэлт өөрчлөлтийн агуулга
1	Хархорин сум хөдөөгийн нэгдсэн эмнэлэг РД-9045074 1070002018 ЭУ-а/388/15/13/27	Эрүүл мэндийн анхан болон дунд шатны эмнэлгийн тусламж үйлчилгээ	Хархорин сум Ганган- Орхон баг	Үйл ажиллагааны чиглэл “Эрүүл мэндийн анхан болон дунд шатны эмнэлгийн тусламж үйлчилгээ” гэснийг “Лавлагаат шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ” болгох, мөн сунгалт хийгдэж байгаа учир шинээр бичиж олгох шаардлагатай
2	“Хужирт тур” ХХК “Хан Хужирт” рашаан сувилал РД-2058472 1011004045 ЭХ-13/23/08	Рашаан сувиллын тусламж үйлчилгээ	Хужирт сум 5-р баг	Үйл ажиллагааны чиглэлд “Сэргээн засах тусламж үйлчилгээ” нэмэлтээр оруулах мөн гээгдүүлсэн учир шинээр бичиж олгох шаардлагатай